



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

# ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ

**7**  
АНГИ

# ФИЗИК

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....

### САНАМЖ


- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

1. Шагай бол Монголчуудын уламжлалт наадгай юм. Шагай нь зөв биш хэлбэртэй учир шагайн эзлэхүүнийг хэмжихэд дараах багажуудаас алийг нь сонгох вэ?

- A. мензурк
- B. секундомер
- C. туузан метр
- D. жинлүүр




2. Монгол банк 2020 онд “Хархорум 800 жил” нэртэй дурсгалын мөнгөн зоос гаргажээ. Түүний масс 62.2 г, түүний диаметрийг зурагт харуулснаар шугам ашиглан хэмжжээ. Зоосны диаметр хэд вэ?




- A. 2.0 см
- B. 5.0 см
- C. 7.0 см
- D. 10.0 см

3. Биеийг өөр, өөр шингэнд хийхэд зурагт үзүүлснээр живж, хөвж байв. Аль шингэн хамгийн ИХ нягттай вэ?




4. Дараах зурагт үзүүлснээр ган бөмбөлгүүдийг мензурктай усанд хийв. Мензуркийн заалтыг уншиж, нэг бөмбөлгийн эзлэхүүнийг олно уу.




- A. 40 см<sup>3</sup>
- B. 30 см<sup>3</sup>
- C. 6 см<sup>3</sup>
- D. 5 см<sup>3</sup>

5. Зурагт штангенциркулийн хуваарийг харуулж байна. Аль нь зөв уншилт вэ?



- A. 2.13 см
- B. 3.25 см
- C. 3.55 см
- D. 2.38 см

6. Жин дээр тавьсан шооны ирмэг 2.0 см бол түүний нягтыг олоорой.




- A. 0.80 г/см<sup>3</sup>
- B. 1.25 г/см<sup>3</sup>
- C. 1.60 г/см<sup>3</sup>
- D. 3.20 г/см<sup>3</sup>

7. Сургууль орчмын бүсэд 20 км/ц-аас илүүгүй хурдтай явахыг анхааруулсан тэмдэг байв. Машин 60 м замыг 10 секундэд туулсан бол машины жолооч хөдөлгөөний дүрмийг зөрчсөн үү?

- A. Машины хурд 1.7 км/ц учир зөрчөөгүй.
- B. Машины хурд 6 км/ц учир зөрчөөгүй.
- C. Машины хурд 20 км/ц учир зөрчсөн.
- D. Машины хурд 21.6 км/ц учир зөрчсөн




8. Дугуйчин бэлтгэл хийжээ. Түүний зам, хугацааны графикийг ашиглан дундаж хурдыг тооцоолно уу.




	Нийт зам, км	Нийт хугацаа, мин	Дундаж хурд, м/с
A	10	50	3.3
B	10	50	200
C	50	10	5
D	5	15	333.3

9. Шингэний температурыг хэмжиж байгааг харуулав. Багажийн заалтыг уншаад температурыг зөв хэмжиж байгаа зургийг сонгоорой.




	Термометрийн байрлал	Шингэний температур, °C
A	1	44
B	2	42
C	3	42
D	4	44

10. Зурагт хоёр шулуун соронзон орны шугамыг үзүүлэв. Соронзон орны шугамыг хойд туйлаас гарч, өмнөд туйл руу орсон байдлаар дүрсэлдэг. Зурагт аль соронзнуудын шугамыг үзүүлсэн байна вэ?




- A.
- B.
- C.
- D.

11. Сурагч төмөр биеийг соронзод татуулахад нөлөөгөөр соронзлогдож, соронзон шинжтэй болжээ. Төмрийн үзүүрт хойд туйл үүссэнийг нэг удаагийн боломж ашиглан шалгаарай.



- A. Төмрийн үзүүрт төмөр бие ойртуулан таталцаж байгаагаар нь мэднэ.
- B. Төмрийн үзүүрт зэс бие ойртуулан таталцаж байгаагаар нь мэднэ.
- C. Төмрийн үзүүрт соронзын өмнөд туйл ойртуулан түлхэлцэж байгаагаар нь мэднэ.
- D. Төмрийн үзүүрт соронзын өмнөд туйл ойртуулан таталцаж байгаагаар нь мэднэ.

12. Шулуун соронзын орчим дахь аль соронзон зүүний байрлалыг буруу харуулсан байна вэ?




13. Дуу тархахтай холбоотой дараах өгүүлбэрүүдээс аль нь буруу вэ?

- A. Дуу чичирхийллээс үүсэж, долгион хэлбэрээр тархдаг.
- B. Дуу хоосон /вакум/ орчинд тархахгүй.
- C. Дууны хурд орчноос хамаарч өөр өөр байна.
- D. Дуу тархах хурд орчны температураас хамаарахгүй.


14. Дуу ойх үзэгдлийг ашиглан биесийн хоорондын зайг хэмжиж болдог. Дууны долгионыг ашиглан аль зайг хэмжих боломжтой вэ?

- A. Далайн гүн
- B. Оддын хоорондын зай
- C. Нар болон дэлхийн хоорондох зай
- D. Дэлхий болон сарны хоорондох зай

15. Дууны долгион осциллоскопын дэлгэц дээр дараах байдлаар харагдав.



Хэрэв дууг сул, нам болгосон бол осциллоскопын дэлгэц дээр ямар зураг харагдах вэ?





20. Ажиглагчтай харьцуулахад Алтан гадас одны байршлыг аль зурагт зөв дүрслэн харуулсан байна вэ?



